

Цахим элсэлтийн тухай

Цахим элсэлт нь 1-р ангид шинээр элсэх гэж буй суралцагчийг хамран сургах тойргын хаяг, харьяалалд нь үндэслэн цахимаар тухайн суралцах ёстой сургуульд нь хүсэлт гаргах үйл ажиллагааг хэлнэ.

2020-2021 оны хичээлийн жилд Нийслэл, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий аймгуудад аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрууд хүсэлт тавьсныг үндэслэн 2020 оны шинэ хичээлийн жилийн 1-р ангийн элсэлтийг цахимаар зохион байгууллаа.

Цахим элсэлтийн хүсэлт гаргахдаа дараах дарааллын дагуу хүсэлтээ гаргаж шийдвэрийн хариугаа эцэг эхийн системээрээ дамжуулан авах боломжтой.